



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 12 сарын 15 өдөр

Дугаар А/835

Булган сум

Хууль бусаар ашигт малтмал олборлох эрэх,  
хайх үйл ажиллагаанд хяналт шалгалт  
хийх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.10, Ашигт малтмалын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны "Булган аймгийн 2023 оны төсөв батлах тухай" XII/21 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрт хууль бусаар ашигт малтмал эрэх, хайх, олборлох үйл ажиллагаа явуулж байна гэх гомдол, мэдээллийг 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс 11 дүгээр сарын 11-ний өдрийг дуустал маршрутын дагуу зохион байгуулсугай.


2. Хяналт шалгалтыг зохион байгуулах удирдамжийг 1 дүгээр, шаардагдах зардлын тооцоо, маршрутыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Захирамжийн хэрэгжилтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулж, ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (А.Гантөмөр), Цагдаагийн газрын дарга (дэд хурандаа Г.Ганбаяр), сумын Засаг дарга (М.Бадам) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Дээрх арга хэмжээнд шаардагдах зардал 202,980 (Хоёр зуун хоёр мянга есөн зуун ная) төгрөгийг Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ





## ХАМТАРСАН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ АЖЛЫН УДИРДАМЖ

### Нэг. Шалгалтын зорилго

“Байгаль орчныг хамгаалах тухай”, “Ашигт малтмалын тухай”, “Газрын хэвлийн тухай”, “Усны тухай”, “Төрийн хяналт шалгалтын тухай” хуулиуд болон тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг шалгаж, зөрчил дутагдал гарахаас урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах цаашид авах арга хэмжээний саналыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлэхэд хяналт шалгалтын зорилго оршино.

### Хоёр. Шалгалтад хамрагдах хүрээ

Бүрэгхангай сумын 1-р багийн нутаг дэвсгэрт хууль бусаар алт олборлож буй газар

### Гурав. Хяналт шалгалтын бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн дарга: Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

А.Гантөмөр

Гишүүд: Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн С.Амар

Аймгийн Засаг даргын тамгын газрын Геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч Т.Наранцацралт

Байгаль орчны хяналтын улсын байцаагч Б.Золбаяр

Бүрэгхангай сумын Экологийн Асуудал хариуцсан байцаагч, ахмад Ж.Энхболд

Сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч Н.Өсөхбаяр

Хяналт шалгалтыг 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс 11 дүгээр сарын 11-ний өдрийг дуустал маршрутын дагуу зохион байгуулна.

### Дөрөв. Хийж гүйцэтгэх ажил

Хууль бус ашигт малтмал олборлох зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох арга хэмжээ авах, ашигт малтмал олборлох, эрэх, хайх үйл ажиллагаа явагдсан нөхцөл байдалтай танилцах,

Хууль бусаар ашигт малтмал олборлосон газрын хэмжээг тогтоох, нөхөн сэргээлт хийсэн талбайг хүлээн авах,

### Тав. Шалгалтын дүнг танилцуулах

Шалгалтаар илэрсэн зөрчил, авсан арга хэмжээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх мэдээллийг ажлын хэсэг аймгийн Засаг даргад танилцуулна.

12 дугаар сарын 15-ны өдрийн А/835 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



ХУУЛЬ БУСААР АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОЖ БУЙ ГАЗАРТ  
ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ЗАМЫН МАРШРУТ

Д/д	Хяналт шалгалт явуулах чиглэл	Явах замын хэмжээ /км/	Хугацаа
1	2	3	4
1	Булган - Бүрэгхангай	80	1
2	Бүрэгхангай-Уйлант 1-р баг	70	
3	Уйлант 1-р баг-Бүрэгхангай	70	
	Бүрэгхангай-Булган	80	
	Нийт	300	1

ХУУЛЬ БУСААР АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОЖ БУЙ ГАЗАРТ  
ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХЭД ЗАРЦУУЛАХ ХӨРӨНГӨ

Д/д	Зардал	Зарцуулах	Нэг бүрийн өртөг	Нийт өртөг
1	2	3	4	5
1	Шатахуун	$300/100*17=51$ л	3 980 төг	202 980
	<b>Дүн</b>			202 980